



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2022 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 122

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн  
төлөөлөл хэрэгжүүлэх гишүүдийг томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 2.10, 4.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 05/4685 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг харгалзан “Цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнээр Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дарга З.Энхболд, Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга Б.Доржсэмбэд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Барилга, хот байгуулалтын яамны Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Гантулга, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дэд дарга А.Ариунболд, Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга Д.Нарангэрэл нарыг 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс томилсугай.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132007679

\Huraldaanii material\2022 on\2022.04.05 9-r huraldaan.docx